



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/36

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6 дугаар заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” 302 дугаар тушаалаар батлагдсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн 2 дугаар хэсгийн 2.1, 2.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх хөндлөнгийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Т.Үржинпүрэв (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Бундмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Анхтуяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ч.Батсуурь (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Л.Ишханд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

2. Сонгон шалгаруулалтыг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны дотор зохион байгуулж, удирдамжийн дагуу хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Т.Үржинпүрэв)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНБОЛД

012100147

D: My Doc. Tushaal. ZDTG